



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/804

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдол ихтэй бүсэд байршиж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод агаарын чанарын судалгаа хийж, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|----------------------|--|
| Ахлагч | -Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч |
| Гишүүд: | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
-Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга;
-Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;
-Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга. |
| Нарийн бичгийн дарга | -Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга. |

2. Саналаа 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020004163



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар A/805

Улаанбаатар хот

Агаарын бохирдлыг бууруулах
талаар авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зохих журмын дагуу тогтмол хяналт тавьж, хяналт шалгалтын тайланг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчид тухай бүр танилцуулж ажиллахыг Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар /М.Дэлгэрэх/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т тус тус даалгасугай.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасны дагуу хийх хяналт шалгалтын ажлын удирдамжийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгаланд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020004161

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ж. БАТБАЯСГАЛАН

АГААР БОХИРДУУЛАГЧ ТОМООХОН СУУРИН ЭХ ҮҮСВЭР АШИГЛАГЧ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙЖ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Шалгалт, магадлан итгэмжлэх ажлын зорилго, үндэслэл:

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт уурын болон усан халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Агаарын тухай”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай”, “Газрын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Эрчим хүчний тухай” хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, журам, стандарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хаягдал утааны хийн хэмжилт хийж магадлан итгэмжилж, стандарт хангахгүй зуухнуудыг шинэчлүүлэх санал, дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт шалгалт, магадлан итгэмжлэх ажилд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, объектын нэр, хамрах хүрээ:

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уурын зуух, 100 кВт-аас дээш нэгж хүчин чадалтай халаалтын зуухнуудын байгаль орчинд нөлөөлөх байдалд хяналт, шалгалт хийж, утааны хийн хэмжилтийн дагуу магадлан итгэмжлэх ажлыг зохион байгуулна.

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсэг нь хэмжилт, шалгалтын гэсэн 2 багаас бүрдэх бөгөөд Агаарын бохирдлыг бууруулах газар, Япон улсын ЖАЙКА байгууллагын инженер, мэргэжилтнүүд, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчид, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтнүүд оролцоно. (Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1-р хавсралтаар үзүүлэв.)

Холбогдох байгууллагын удирдлага нар (Ажлын хэсгийн ахлагчаас бусад) ажлын хэсгийн гишүүдийг УХЗ-ны магадлан итгэмжлэлийн ажилд дагнаж ажиллах боломжоор хангаж өгнө.

Дөрөв. Шалгалт, магадлан итгэмжлэх ажлын эхлэх болон дуусах хугацаа:

Шалгалтыг 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.

Тав. Шалгалт, магадлан итгэмжлэх ажлын чиглэл, хамрагдах асуудал:

Хяналт шалгалт, магадлан итгэмжлэлийг гүйцэтгэх ажил үүргийн хуваарь болон төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. МХЕГ-ын даргын баталсан 2.3 дугаартай “Дулааны цахилгаан станц, хэсгийн халаалттай уурын зуух, нам даралтын зуухны байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг ашиглан үнэлэлт өгнө. Хяналтын хуудсаар хийгдсэн шалгалтын дүнгээр эрсдэлийг тодорхойлж мэдээллийн санд оруулна.

2. Суурин эх үүсвэрээс агаарт гаргаж буй бохирдуулагч бодис CO, NO_x SO₂, тоосонцрын хэмжээнд хэмжилт хийн “Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5457:2005 стандарттай харьцуулан дүгнэлт гаргана. Халаалтын зуухны байгууламжийн үйл ажиллагаанд хэмжилт, шалгалт хийж үнэлгээ өгөх тоон үзүүлэлтүүдийг хавсралт 2-оор дүгнэнэ.

3. 2015-2016 онуудад хүргүүлсэн улсын байцаагчдын гаргасан эрх зүйн акт шийдвэрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.

4. Агаар бохирдуулагч бодисыг саармагжуулах, цэвэрлэх физикийн сөрөг нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмжөөр тоноглогсон байдалд,

5. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын гэрээний хэрэгжилт, тээвэрлэлт, орчны эрүүл ахуйн байдалд, /нүүрс, үнс хадгалах агуулах байгаа эсэх/.

6. Зуухны нэгдсэн бүртгэлийг хийж мэдээллийн санд баяжуулалт хийнэ.

Зургаа. Шалгалт, магадлан итгэмжлэх ажлын үр дүнг тайлагнах:

Хяналт шалгалт, магадлан итгэмжлэлээр хангалтгүй дүн үзүүлсэн зуухны байгууламж эрхлэгчид илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар эрх зүйн акт шийдвэрийг гарган биелэлтийг хангуулах ба иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлнэ.

Хяналт шалгалт, магадлан итгэмжлэлийн дүнг нэгтгэн, танилцуулга бичиж ажлын хэсгийн ахлагчид хүргүүлнэ. Хяналт шалгалт хийсэн улсын байцаагчид шалгалтын танилцуулга, хяналтын хуудасны мэдээллийн сан, зуух, зуухны байгууламжийн нэгдсэн мэдээллийн санг 2017 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн дотор Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэст ирүүлнэ.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/17 дугаартай тушаалын дагуу шалгалтын дүнг 21 хоногийн дотор зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ 5 хоногт авч ажиллана.

Хяналт шалгалт, магадлан итгэмжлэлийн нэгдсэн дүнг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдол хариуцсан орлогчид Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулсны дараа танилцуулж, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хяналт шалгалтаар хийж гүйцэтгэсэн ажил, авсан арга хэмжээ, танилцуулгыг стандартын дагуу бичиж тогтоосон хугацаанд ирүүлсэн байдлаар улсын байцаагчдыг дүгнэх ба газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тус дүн танилцуулагдана.

Шалгалтын мэдээллийн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/21 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн

мэргэжлийн хяналтын газраас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, байгууллагын вэб сайтын үйл ажиллагааг зохицуулах журам"-д заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Долоо. Төлбөр болон тариф, хэмжилт шалгалтын зардлын төсөвт, тооцоо

Уурын болон усан халаалтын зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хэмжилт шалгалтын ажил үйлчилгээний хураамжийн хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтыг үндэслэх ба хураамжийг Төрийн сан Банкны 200051052 тоот дансанд төвлөрүүлнэ.

Хэмжилт шалгалтын зардлын төсвийн дэлгэрэнгүйг хавсралт 3-аар үзүүлэв.

ХЯНАСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА


Т.ГАНТӨМӨР

ТАНИЛЦСАН:

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ


М.ДЭЛГЭРЭХ

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДЭД ДАРГА


С.ДАВААСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ,
УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.БАТ-ӨЛЗИЙ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ГАЗРЫН АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


Х. ГАЛЫМБЕК

БОЛОВСРУУЛСАН:

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН


С.БАТСАЯ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН


Г.УРАНЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


Н.НАРАНГЭРЭЛ

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлын хэсэг нь хяналт - судалгааны, хэмжилтийн гэсэн 2 багаас бүрдэж ажиллана.

Хяналт-судалгааны багт: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчид, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын, дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын дэд бүтэц, тохижилтийн хэлтсийн мэргэжилтнүүд.

Хэмжилтийн багт: Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын мэргэжилтнүүд, Япон улсын ЖАЙКА байгууллагын инженер, мэргэжилтнүүд хэмжилтийн багийг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд ажлын хэсэг 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын Агаарын чанарын хяналтын хэлтсийн дарга
Хяналт- судалгааны баг	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч СБД дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын байцаагч ЧД дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч СХД дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын байцаагч ХУД дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын байцаагч БГД дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын байцаагч Нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүн Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын инженер Баянгол дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн Баянзүрх дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн Сүхбаатар дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн Хан-Уул дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн Чингэлтэй дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн Сонгинохайрхан дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн
Хэмжилтийн баг	ЖАЙКА төслийн нэгжийн мэргэжилтнүүд хэмжилтийн багийг удирдлагаар хангаж ажиллана Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын мэргэжилтнүүд оролцоно.

**Халаалтын зуухны байгууламжийн
үйл ажиллагаанд хэмжилт, шалгалт хийж
үнэлгээ өгөх тоон үзүүлэлтүүд**

1. Утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээний хийн шинжилгээний дүн					
	Үнэлгээний үзүүлэлтүүд	Стандарт үзүүлэлт	Батлагдсан оноо	Хэмжилтийн дүн	Шалгагдсан оноо
100-800 кВт хүртэлх хүчин чадалтай зуухны утааны хийн үзүүлэлт					
1.	Азотын дан ба давхар исэл (NOx)	450 мг/м ³	2		
2.	Хүхрийн давхар исэл (SO ₂)	800мг/м ³	20		
3.	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	2500 мг/м ³	8		
4.	Дэгдэмхий үнс	400 мг/м ³	30		
Нийт оноо			60	-----	
800кВт-аас 3,15 мВт хүртэл хүчин чадалтай зуухны утааны хийн үзүүлэлт					
1.	Азотын дан ба давхар исэл (NOx)	400 мг/м ³	2		
2.	Хүхрийн давхар исэл (SO ₂)	600 мг/м ³	20		
3.	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	2000 мг/м ³	8		
4.	Дэгдэмхий үнс	300 мг/м ³	30		
Нийт оноо			60	-----	
2. Дотоод агаарын чанар, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны шаардлага					
1.	Дотоод орчны тоосонцор PM 2.5	0,05 мг/м ³	5		
	Дотоод орчны тоосонцор PM 10	0,1 мг/м ³			
2.	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	60 мг/м ³	5		
3.	Ажлын байранд байрласан хөдлөх механизм нэг бүрт гадна талаар нь хашлага хамгаалалт хийсэн эсэх		1		
4.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр, байдаг эсэх		1		
5.	Галч, галчийн сургалт болон ХХАА-ны сургалтанд хамрагдсан эсэх		5		
Нийт оноо			17	-----	
3. Техникийн ерөнхий шаардлага					
1.	250 кВт- аас дээш (250 ороод) нэгжийн хүчин чадалтай зууханд утааны хийг үнслэгээс цэвэрлэх төхөөрөмжтэй эсэх		10	-----	
2.	Зуухны утааны яндан нь барилгын дээврийн хамгийн өндөр хэсгээс “2 метрээс багагүй” байгаа эсэх		1	-----	
3.	Нүүрс, үнсний битүү агуулахтай эсэх		10	-----	
4.	Техник ашиглалтын паспорт бичиг баримт нээсэн эсэх, хөтлөлт		2	-----	
Нийт оноо			23	-----	
Ерөнхий оноо			100	-----	

Халаалтын зуухны байгууламжийн үйл ажиллагаанд хэмжилт, шалгалт хийж үнэлгээ өгөх тоон үзүүлэлтүүдийн нийлбэр 71 онооноос дээш байсан тохиолдолд халаалтын зуухыг “тэнцэнэ” гэж үзнэ. Бусад тохиолдолд “тэнцэхгүй” гэж үзнэ.

Шалгалтын зардлын төсөв

Хяналт шалгалт, магадлан итгэмжлэх ажилд шаардагдах зардлын дэлгэрэнгүй хүснэгт:

Хэмжилт, шалгалтын багийн зардал /2016-2017 оны 11.15-03.31-ний өдөр хүртэл/					
	Зардлын товчоо	Хэмжих нэгж	Нэг өдөрт /төгрөг/	Нийт хугацаа /өдөр/	Нийт санхүүжилт /төгрөг/
1.	Шатахууны зардал А-баг	2 автомашин	80,000	30	2,400,000
2.	Шатахууны зардал Б-баг	2 автомашин	80,000	30	2,400,000
3.	Тоосонцрын фильтр /250/	ш	-	200	1,400,000
4.	Багажны принтерийн цаас /10/	ш	-	-	400,000
5.	Бичиг хэргийн зардал	10 хүн	-	-	200,000
6.	Хөдөлмөр хамгааллын бээлий, маск, хошуувч	20 хүн	40000	-	800,000
7.	Хөдөлмөр хамгааллын гадуур хувцас /хос/	10 хос	400,000	-	4,000,000
8.	Бусад зардал	-	-	-	150,000
Нийт зардал				30	11,950,000